ДЭЛХИЙН ХҮН

**"МЭДЛЭГИЙН ГОЛ ДАЙСАН НЬ МУНХАГЛАЛ БИШ, ТӨӨРӨГДӨЛ**

...50 гаруй жилийн тэртээ эмч нар нэгэн залууг удаан амьдрахгүй гэж итгэлтэйгээр хэлсэн байдаг. Гэхдээ тэр эр өнгөрсөн сарын эхээр 75 настайгаа золгосон. Энэ хүн бол Английн физикч Стивен Уильям Хокинг. Хүн төрөлхтний урагшлах зам бол шинжлэх ухааны хөгжил...

С2 нүүрэнд

ӨДРИЙН СУРВАЛЖИЛГА



Э.ХАРЦАГА FOCUS

# ЦААСАН УРЛАЛЫН БРЭНДТЭЙ БОЛОХООР ЗОРЬЖЭЭ

Б.БУЯНДАЛАЙ

Тэргэнцэртэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, идэвх, оролцоог сайжруулах зорилготой төслийн нээлт өчигдөр боллоо. Энэ үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урласан цаасан урлалын бүтээлүүдийг дэлгэв. Австрали улсын Элчин сайдын яамны DAP хөтөлбөрийн хүрээнд зарласан бичил бизнесийг дэмжих уралдаанд Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны төсөл шалгарч, 30 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Зургаан сарын турш үргэлжлэх "Eco gift" төсөлд 10 гаруй, сургалтад 30-40 иргэн хамруулахаар төлөвлөжээ. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн бусад төсөөс юугаараа онцлог, давуу талтайг Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн Б.Чулуундолгор "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тогтмол ажил, орлоготой болох замаар нийгэмд эзлэх байр суурь, оролцоог нь нэмэгдүүлэх зорилготой. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн олонх нь нийгмээс тусгаарлагдан, гэртээ амьдардаг. Гэхдээ тэд ажил эрхлэн, эрх мэдэлтэй болох тусам шийдвэр гаргах чадвар нь тодорхой хэмжээгээр нэмэгддэг. Санхүүжүүлж, аливаа зүйлийг хэрхэн хийхийг заахаас гадна түүнийгээ зах зээлд борлуулж, хэрэглэгчдийн гарт хүргэх маркетингийн сургалт явуулж буйгаараа онцлог. Энэ төсөлд хорих ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийг хамруулахаар зорьж байна. Манай холбоо 2005 байгуулагдсан. Одоогоор зургаан аймагт салбартай, давхардсан тоогоор 1000 гаруй гишүүнтэй. Бид цаасаар бэлэг дурсгал, гоёл чимэглэлийн зүйл урлаж байна. Дэлхий даяар эко үйлдвэрлэлийг дэмжиж буй. Бид ч бас хувь нэмрээ оруулъя гэж бодсон. Цаасан урлалын "Eco gift" брэндтэй болох зорилготой. Борлуулалтын сүлжээтэй, нэрийн дэлгүүртэй болчихвол сайхан аа. Бидний бүтээлээ урладаг гол түүхий эд бол цаас. Танай сонины хамт олон өнгөрсөн жил биднийг дэмжиж, 500 кг цаас бэлэглэсэн нь зардал хэмнэж байна. Одоо хүртэл дуусаагүй байгаа шүү дээ. Сонины зах цаас болохоор бичигүй, будаг сайн шингээдэг. Энэ дашрамд Б.Нандинтүшиг эрхлэгчтэй "Өнөөдөр" сонины хамт олонд баярлаж явдгаа илэрхийлье" гэлээ.

Харин Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны гишүүн Б.Болормаа "Ажилгүй, гэртээ суух хэцүү. Энэ холбоонд элссэнээс хойш би өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй гэж бодохоо больчихсон. Над шиг олон эмэгтэйд энэ төсөл гэрэл гэгээ, итгэл найдвар бэлэглэх нь лавтай" хэмээв.



МУЗЕЙ

## Дундговийн үзмэрүүдийг сэргээн, засварлажээ

Б.ДӨЛ

Соёлын өвийн төвийн Б.Мягмарсүрэн тэргүүтэй дөрвөн мэргэжилтэн Дундговь аймгийн музейд энэ сарын 3-7-нд ажиллан 20 гаруй үзмэр сэргээн засварлажээ. Үүнд XVII-XIX зуунд хамаарах шашны болон түүх, соёлын үзмэр буюу зурмал танка бурхан 15, ширэн цартай морин хуур нэг, хүрэл тогоо гурав багтсан байна. Хүрлийн үеийн олдворынхоо тоогоор орон нутгийн музейнүүдийг тэргүүлдэг уг байгууллагад 2016 оны арванхоёрдугаар сарын тооллогоор 4678 үзмэр байна. Ирэх долоо хоногт уг музейд "Хүрлийн үеийн урлагийн гайхамшиг" үзэсгэлэн дэлгэх нь. Энэ үеэр музейн сан хөмрөгөөс 700 гаруй, нутгийн иргэдийн цуглуулгаас 300 орчим үзмэр толилуулна.

ӨД БЭХ

## Францад Монголын сэдэвт яруу найргийн өдөрлөг болов

Парис дахь Монакогийн соёлын ордонд монгол сэдэвт яруу найргийн өдөрлөг зохион байгуулжээ. Монгол Улсаас Бүгд найрамдах Франц улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Батсайхан, Монакогийн Вант улсын Элчин сайд тэргүүтэй найман орны элчин сайд, консул уг арга хэмжээнд оролцсон аж. Энэ үеэр "Чингис хаан" одонт, Соёлын гавьяат зүтгэлтэн О.Мэнд-Ооёогийн "Чам руу би явж байна", "Уулсын дүрийг тайлахуй", "Өөрийн эгшиг", "Морин цаг", "Гэрэлтэх агиин бүр", "Цаглашгүй гэрэлт", "Чулууны аялгуу", "Хээр талаас бичсэн захидал" зэрэг шүлгийг франц хэлээр жүжигчин, кино найруулагч Энн Силвия Мейза уран яруу уншин сонирхуулжээ. Мөн манай орноор хоёр удаа аялсан Монакогийн яруу найрагч Сабин Реглион монголын тухай сэдэвт шүлгүүдээсээ уншсан байна. Тэрбээр Монголын тухай шүлэг бүхий яруу найргийн хоёр ном хэвлүүлсэн гэнэ.

ЦИРК

## "Шонхоодой"-гийнхон Турkт аялан тоглолоо

Б.ДӨЛ

Эмзэг бүлгийн хүүхдүүдийг циркээр дамжуулан нийгэмшүүлэх, орон нутагт энэ чиглэлийн урлагийг хөгжүүлэх зорилгоор Дархан-Уул аймагт 2006 онд байгуулсан "Шонхоодой" ардын циркийнхэн Турк улсад аялан тоглоод иржээ. Т.Төмөр багштай, 12-23 насны 12 уран бүтээлч өнгөрсөн оны зургадугаар сараас зургаан сарын хугацаатай Анталь хотод тоглосон байна. Цагираагаар болон дээсээр наадагч, хөлөөр шидэгч зэрэг үзүүлбэртэй тоглолтоо тэд 120 гаруй удаа толилуулсан аж. Т.Төмөр "Бид орон нутгийн циркийнхнээс бүрэлдэхүүнээрээ гадаад улсад аялан тоглосон анхны хамтлаг боллоо" гэв. Тэд Турkт толилуулсан хөтөлбөрөөрөө аймгийнхаа ЕБС-иудад аялан тоглохоор төлөвлөжээ.

VACANCY ANNOUNCEMENT